

Хялбар механизмт хөдөлгөөнт тоглоом зохион бүтээх

Дизайн технологи 7-р анги



Хичээлийн зорилго

Дамжуулгын төрлүүдэд суралцаж хөдөлгөөнт тоглоом
зохион бүтээх

Зорилт:

01

Зохион бүтээх
тоглоомын санааг
олох

02

Дамжуулгын
төрлүүдын тухай

03

Бүтээлд ямар
дамжуулага,
хөдөлгөөн, материал
ашиглах тухай

04

Бүтээл хийх турших



01

Зохион бүтээх
тоглоомын
санааг олох

Зургаас санаа авч бүтээлийнхээ загварыг гаргаарай



02

Дамжуулгын төрлүүдийн тухай





Гинжит дамжуулгын хэрэглээ.



Гинж нь олон төрөл, хэлбэрээр ашиглагддаг. Унадаг дугуй гинжин дамжуулгаар хөдөлгөөнд ордог. Дугуйн араг солиход яагаад хурдан удаан болохоос гадна дөрөөг жийхэд хүнд хөнгөн болдог вэ?

Шулуун зам дээр араа нь 1:1,5 дамжуулах харьцаатайгаар явахад тохиромжтой. Харин ууланд явах үед замын бартаанаас хамаарч 1:1 эсвэл 2:1 харьцаатайгаар арааг тохируулан хурдаа бууруулах хэрэгтэй. Хоёр тэнхлэгийн хооронд зайтай үед гинж юм уу оосорт дамжуулга ашиглан хөдөлгөөнийг дамжуулдаг.



Конус араат дамжуулгын хэрэглээ.


Конус араат дамжуулгын бүтцийг эргэн санаарай. Конус арааны хувьд эргэлтийн чигийг зөвхөн 90 градусаар өөрчилж хөдөлгөөн дамжуулдаг онцлогтой. Автомашины хөдөлгүүрийн эргэлдэх хөдөлгөөнийг дугуйнд дамжуулахад ашигладаг.



Цилиндр араат дамжуулгын хэрэглээ.

Цилиндр арааг эргэлтийн хөдөлгөөнийг параллел байрласан голд дамжуулахад ашигладаг. Хөтлөгч араа гэдэг нь бариулыг эргүүлэхэд хөдөлгөөнийг удирдаж байгаа араа, харьцагч араа нь дамжих хөдөлгөөний улмаас хөдөлгөөнд орж буй араа юм.

Цилиндр арааг ашиглан дараах зүйлсийг хийж болно. Үүнд: Хөдөлгүүрийн нэг минут дахь эргэлтийн тоог өөрчлөх, эргэлтийн хүчийг ихэсгэх юм уу багасгах, эргэлтийн чиглэлийг өөрчлөх.



03

Бүтээлд ямар дамжуулага, хөдөлгөөн, материал ашиглах тухай



Ямар дамжуулга хэрэглэх

Шүдэт, гинжит, оосорт, шурган, үрэлтийн, цилиндр араат, конус араат дамжуулгаас сонгон хэрэглэх



Ямар хөдөлгөөн оруулах

Ухрах, давших, эргэх, савлах хөдөлгөөн, дуугардаг, гэрэл асдаг, өөрөө явдаг, өнхөрдөг, алхдаг гэх мэт хөдөлгөөнөөс сонгох



Ямар материал ашиглах

Гар доорх материал, хаягдал материал ашиглах /Цаас, хуванцар, төмөр гэх мэт/

★Төлөвлөх чиглэл /тайлбарлах/

Төлөвлөх чиглэл	Анхны санаа	Сайжруулах санаа
Ямар хөдөлгөөн хийх		
Ямар техникийн ямар эд ангиуд ашиглах		
Дамжуулгын төрлөө сонгох		
Ямар өнгө, хэлбэр, дизайнтай байх	Тойм зураг	Хэмжээ тавиарай
Материалаа сонгох		
Хийх технологио төлөвлөх		

04

★ Бүтээл
хийх
★
турших



Бүтээл хийхдээ санаа аваарай



Бүтээл хийх хайрцаг цаасаа бэлтгэнэ. Өөрийн бүтээлд тохируулан хэмжээг авч цаасаа тэгш өнцөгт хэлбэрээр зүсэж бэлгэнэ. Урт 4ш /15x7/, богино 4ш /9,5x7/. Бэлтгэсэн цаасыг 2x2ш-ээр нэгтгэн наана.



2 богино цаасны голыг нүхлэнэ. 4ш дугуй дүрс бэлтгэнэ. Гортиг болн сав ашиглаж болно. /Диаметр 3см/



Дугуй дүрс дээр 6ш шүдэнз нааж тогтооно. Дээр нь дахиад 1 дугуй дүрсээ наана. 2ш араа бэлэн болно. Дууссан эсвэл гархаа больсон үзгээр гол хийж болно. /Эсвэл мод, төмөр, савх, ... гэх мэт төрөл бүрийн материалаар хийж болно.



2x2-оор нь нэгтгэсэн 4ш цаасаа дөрвөлжилж наана.



Хажуу тийш хазайхаас хамгаалсан гол тулгуур хийнэ.



Хөдөлгөөн хийх голыг
төмөр утас, савх мод
ашиглан хийж болно.
Сугарахаас хамгаалж
үзүүрт нь цэцэг хийж
өгөв.






Дээр нь хөдөлгөөн хийх чимэглэх
материал



Дээр нь хөдөлгөөн
хийх чимэглэх
материал



Бүтээл маань бэлэн боллоо.
Хэрхэн хөдөлгөөн хийж буйг бичлэгээс үзээрэй.





**Анхаарал
хандуулсанд
баярлалаа.**